



**ЗАМ, ТЭЭВРИЙН  
ХӨГЖЛИЙН ЯАМ**

**ДАЛАЙ АШИГЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД  
ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ  
ТАЙЛАН**

**Улаанбаатар хот  
2019 он**

## **ДАЛАЙ АШИГЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

УИХ-аас 2015 онд баталж, 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж буй “Хууль тогтоомжийн тухай хууль” болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцов.

Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог дурдсан аргачлалын дагуу тооцохдоо иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлын ачааллыг тооцож, цаашид гарах ачааллыг багасгах санал боловсруулахад энэхүү судалгааны зорилго оршив.

### **1. Иргэнд үүсэх зардал**

Өнөөгийн байдлаар далай ашиглах үйл ажиллагаа, түүний дотор хөлөг онгоц бүртгэх ажиллагаа Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна далайн эрэг бүхий улс орнууд болон гадаад их далайд явагдаж байгаа учир Монгол Улсын иргэд энэхүү үйл ажиллагаанд оролцох боломжгүй тул иргэнд зардал үүсэхгүй болно.

Иймд Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын 1.5 дахь хэсэгт заасан журмын дагуу зардлыг зөвхөн хуулийн этгээдийн зардал, төрийн байгууллагын зардал гэсэн хоёр төрлөөр тооцлоо. Үүнд:

### **2. Хуулийн этгээдэд үүсэх зардал**

Монгол Улсын Их Хурал “Далай ашиглах тухай” хуулийг 1999 онд баталж, Далайн эрх зүйн НҮБ-ын 1982 оны конвенц болон Олон улсын далайн байгууллагын үндсэн конвенциудад 1996 онд нэгдэн орж баталгаажуулсан бөгөөд “Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журам”-ыг 1999 онд Засгийн газрын 136 дугаар тогтоол /Засгийн газрын 2003 оны 3 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан/-оор баталсан.

Далайн эрх зүйн эдгээр баримт бичгийн хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Авто тээврийн газар /хуучин нэрээр/ хөлөг онгоцны олон улсын нээлттэй бүртгэл явуулах хамтарсан компани байгуулах хэлэлцээрийг 2001 онд Сингапур Улстай байгуулж, бэлтгэл ажлыг ханган Монгол-Сингапурын хамтарсан “Монголын хөлөг онгоцны бүртгэл” хамтарсан компанийг байгуулж 2003 оны 3 дугаар сард анхны хөлөг онгоцоо бүртгэсэн юм.

“Монголын хөлөг онгоцны бүртгэл” хамтарсан компани нь 2003-2009 он хүртэл жил тутам өссөн үзүүлэлтээр 103-443 сая төгрөгийн орлого улсын төсөвт оруулж байсан бол тус компанийг 2010 онд хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөн зохион байгуулснаар уг компанийн ашиг орлого буурч, улмаар Монгол Улсын төсөвт орох орлого 115 сая төгрөг болж буурсан. 2012-2014 онуудад 274 сая хүрч өссөн боловч сүүлийн 4 жилд 150-210 сая төгрөг орчим байна.

Монголын хөлөг онгоцны бүртгэл хамтарсан компани 2003-2018 оны хугацаанд 30 гаруй улсын 3500 орчим хөлөг онгоцыг нээлттэй бүртгэлд хамруулж, бүртгэлийн үйл ажиллагаанаас улсын төсөвт 4.0 тэрбум гаруй төгрөгийг төвлөрүүлсэн ба сүүлийн гурван жилийн орлогын дунжийг авч үзэхэд 1 жилд 1.126.350 ам. доллар болно.

Сүүлийн гурван жилийн дунджаар энгийн бүртгэлтэй хөлөг онгоцны бүртгэлээс жилд 1.076.093 ам. доллар, нэг удаагийн аяллын бүртгэлтэй хөлөг онгоцны бүртгэлээс 32.519 ам. доллар, ВВС /бербөүт чартер/ бүртгэлтэй хөлөг онгоцны бүртгэлээс 17.737 ам. доллар орлоготой ажилласан.

Монголын хөлөг онгоцны бүртгэл хамтарсан компанийн Монголын талын зардлыг хүснэгтээр харуулав.

Хуулийн этгээд	Гүйцэтгэх ажил үйлчилгээ	Ажил үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан	Тохиолдлын тоо /жилээр/
Монгол-Сингапурын хамтарсан “Монголын хөлөг онгоцны бүртгэл” ХХК	Монгол Улсын Төрийн далбаа мандуулах хөлөг онгоцыг бүртгэх, хөлөг онгоцны техникийн хяналт, үзлэг оношилгоо хийлгэх, тэдгээрт далбааны эзэн улсын хяналт тавих, далайчны мэргэжлийн диплом, гэрчилгээг баталгаажуулах	“Монголын хөлөг онгоцны бүртгэл” ХХК -ийн Монгол ажилтнууд-4	Ажлын өдөр бүр
Нэг бүртгэгчийн цалин, байрны зардал /нэг жил/ 71.000 ам.доллар			184.600.000₮
Тоон үзүүлэлт			4 ажилтан
71.000*4=284.000\$*2600₮			738.400.000₮
Цалингийн зардал /жилээр/			923.000.000 ₮
Үйл ажиллагааны нийт зардал==>1.087.271\$*2394₮			2.602.928.018₮

Энэ оны эхний улирлын байдлаар Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд 389 хөлөг онгоц бүртгэгдэн Монгол Улсын Төрийн далбаа мандуулан гадаад их далайд тээвэр хийж байна.

Иймд Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталснаар хуулийн этгээдээс нэмэлт зардал гарахгүй болно.

### 3. Төрийн байгууллагын зардал

Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталснаар Төрийн байгууллагад буюу улсын төсөвт үүсэх зардлыг тооцохдоо тухайн ажил үйлчилгээг үзүүлэх хүний нөөц, түүнд шаардагдах материаллаг зардлыг тооцох чиглэлийг баримталсан.

#### Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох:

Монгол улсын Далайн захиргаа нь Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2007 оны 146 дугаар тушаалаар анх байгуулагдсан тус яамны харъяа байгууллага бөгөөд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн

12 тоот тушаалаар шинэчлэн байгуулагдаж 1 хэлтэс, 3 алба, нийт 25 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

д/д	Албан тушаал	Орон тоо	
1	Дарга	1	
2	Захиргаа удирдлагын хэлтсийн дарга	1	
3	Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	2	
4	Хууль тогтоомж, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн	1	
5	Мэдээллийн сүлжээ, техник хангамж хариуцсан мэргэжилтэн	1	
6	Олон улсын гэрээ, эрх зүй хариуцсан мэргэжилтэн	2	
7	Нягтлан бодогч	1	
8	Бичиг хэрэг, архив хариуцсан мэргэжилтэн	1	
9	Нярав	1	
10	Жолооч	1	
11	Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын албаны ахлах мэргэжилтэн	1	
12	Хөлөг онгоцны бүртгэл хариуцсан мэргэжилтэн	1	
13	Далбааны эзэн улсын хянан шалгагч	3	
14	Далайн тээвэр, боомт ашиглалтын албаны ахлах мэргэжилтэн	1	
15	Далайн тээвэр, логистик хариуцсан мэргэжилтэн	2	
16	Боомт ашиглалт хариуцсан мэргэжилтэн	1	
17	Усан замын тээврийн бүртгэл, хяналтын албаны ахлах мэргэжилтэн	1	
18	Усан замын тээврийн хяналтын улсын байцаагч	2	
19	Усан замын тээврийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн	1	
<b>НИЙТ</b>		<b>25</b>	
Төрийн байгууллага	Гүйцэтгэх ажил үйлчилгээ	Ажил үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан	Тохиолдолын тоо /жилээр/
Далайн захиргаа	Монгол Улсын Төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцоор далайн баялаг олборлох, загас агнах, тээвэр, далайн шинжлэх ухааны судалгаа хийх зэрэг далай ашиглах үйл ажиллагаа явуулах, далай дахь аюулгүй байдлыг хангах, далайн орчныг хамгаалах	Далайн захиргааны нийт 25 ажилтан	Ажлын өдөр бүр
Ажилтны дундаж цалин хөлс /нэг жилд/			20.983.320 ₮
Тоон үзүүлэлт			25 ажилтан
Давтамж			12 сар
Нийт зардал /жилээр/			524.583.000 ₮

### **Хууль тогтоомжийн зохицуулалт:**

Монгол Улсын Их хурал 1999 онд баталсан “Далай ашиглах тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг 2007 оны 8 дугаар сарын 2-ны өдөр УИХ баталснаар Далайн захиргаа байгуулах асуудал хуульчлагдсан. Үүнд:

Далай ашиглах тухай хуулийн 8<sup>1</sup> дугаар зүйл.

8<sup>1.1</sup>.Монгол Улсын далайн захиргаа байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн шийдвэрлэнэ.

8<sup>1.2</sup>.Далайн захиргаа нь үйл ажиллагааныхаа орлого болон улсын төсвөөс хуваарилсан хөрөнгөөр санхүүжинэ.

### **Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ:**

Далайн захиргаа нь Монгол Улсын олон улсын гэрээний дагуу дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- далай ашиглах үйл ажиллагааны удирдлагаар хангаж, хяналт тавих;
- хөлөг онгоцны байгууламж, хөдөлгүүр, бусад тоног төхөөрөмжид техникийн хяналт тавих;
- хөлөг онгоцон дээр ажиллагсад, зорчигчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах,
- ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах;
- далай ашиглах үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах;
- хөлөг онгоцноос далайг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх, бохирдсон үед холбогдох арга хэмжээ авах;
- далайн чиглэлээр дотоод, гадаадын холбогдох байгууллагатай хамтарсан сургалт зохион байгуулах, мэргэжилтэй ажилтан сургах, давтан сургах, мэргэшүүлэх;
- гадаад орны эрх бүхий байгууллагаас олгосон далайчны үнэмлэхийг хүлээн зөвшөөрөх;
- хөлөг онгоцны багийн бүрэлдэхүүнд ажиллах үндэсний боловсон хүчний ойрын болон хэтийн хэрэгцээг тодорхойлох, түүнийг олон улсын зохих гэрээнд нийцүүлэн бэлтгэх ажлыг зохион байгуулах.
- Хөлөг онгоц бүртгэх журмыг Засгийн газар батална.

Хүний нөөцийн хэрэгцээ: 25 ажилтан

(тохиолдлын тоог тогтоох боломжтой)  
Тохиолдол бүрт зарцуулах  
хугацаа х Тохиолдлын тоо

(тохиолдлын тоог тогтоох боломжгүй)  
Ажилтны тоо, ойролцоогоор  
25 ажилтан

Хүний нөөцийн хэрэгцээ х Зардал=Хүний нөөцийн зардал

(үндсэн цалин+ нэмэгдэл+бусад нэмэгдэл) = жилд 20.983.320 ₮  
25 ажилтан х 20.983.320 ₮=524.583.000 ₮

Хүний нөөцийн зардал
524.583.000 ₮
+
Материаллаг зардал
/байрны түрээс+эд хөрөнгийн элэгдэл хорогдол+цахилгаан+дулаан+бичиг хэрэг+техник тоног төхөөрөмж+урсгал болон хөрөнгө оруулалт.../= жилд 579.938.190 ₮
+
Бусад зардал / =5.400.000 ₮
НИЙТ ДУНДАЖ ЗАРДАЛ =1.109.921.190 төгрөг

Төрийн байгууллага буюу Далайн захиргааны дундаж зардлыг дараах 3 хувилбараар тооцов. Үүнд:

1. Далайн захиргаа нь одоогийн статусаа хэвээр байлгах тохиолдолд тус байгууллагын нийт ажилтны цалингийн болон үйл ажиллагааны зардал болох 1109921,19 мянган төгрөгийг Монгол-Сингапурын хамтарсан “Монголын хөлөг онгоцны бүртгэл” ХХК-ийн үйл ажиллагааны орлогоос гаргах тул улсын төсөвт шинээр зардал бий болохгүй юм.

2. Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсанаар Далайн захиргааны статусыг Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болгож өөрчлөн зохион байгуулсан тохиолдолд тус байгууллагын нийт ажилтны цалингийн болон үйл ажиллагааны зардлыг Монгол-Сингапурын хамтарсан “Монголын хөлөг онгоцны бүртгэл” ХХК-ийн үйл ажиллагааны орлогоос гаргах тул улсын төсөвт шинээр зардал бий болохгүй юм.

Эндээс Далайн захиргааны статус ийнхүү өөрчлөгдсөн ч гэсэн нэмэлт зардал гарахгүй, төсөвт хүндрэл учрахгүй гэдэг нь харагдаж байна.

3. Харин Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсанаар Далайн захиргааны статусыг Засгийн газрын агентлаг гэж тогтоосон тохиолдолд тус байгууллага төрийн захиргааны байгууллага болох ба ажилтнуудын нэг жилийн цалин Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээнд заасны дагуу тооцвол 206,6 сая төгрөг болж байна.

Хүснэгтээр үзүүлбэл:

Дд	Албан тушаал	Орон тоо	Ангилал	Цалин /1 сар/ ₮
1	Дарга	1	ТЗ-13-1	992.197
2	Захиргааны хэлтсийн дарга	1	ТЗ-10-1	874.164
3	Албадын дарга	3	ТЗ-9-1	806.694*3

4	Албадын ахлах мэргэжилтэн	3	ТЗ-7-1	689.597*3
5	Ажилтнууд	17	ТЗ-6-1	638.906*17
	Нийт орон тоо	25		
	Нэг сарын нийт цалин			17.216.636
	Жилийн цалин			206.599.632

Үүний дээр нэмээд

Материаллаг зардал

/байрны түрээс+эд хөрөнгийн элэгдэл хорогдол+цахилгаан+дулаан+бичиг хэрэг+техник тоног төхөөрөмж+урсгал болон хөрөнгө оруулалт.../= жилд 579.938.190 ₮

+

Бусад зардал /  
=5.400.000 ₮

**Нийт зардал 791.937.822 төгрөг**

Энэ тохиолдолд Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталснаар Далайн захиргааны зардал болох 791.937.822 төгрөгийн зардал улсын төсөвт үүснэ.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ